



СУРАГЧИЙН ӨНДГӨН ТАЙМЕР ЦАГ Т-601

Сурагчийн таймер цаг нь Японы сургуулиудад болон эцэг эхчүүд бага насны хүүхдээ цагийн менежмент болон баримжаанд сургах зорилгоор түгээмэл ашигладаг. Жишээ нь та хүүхдээ 40 минут хичээл хийлгүүлэх эсвэл ном уншуулаад 10 минут амраад дахин 40 минут хичээл хийхийг сэрүүлэгтэй цаг дээр тохируулаад өгвөл хүүхэд цагийн хуваарьт дасан зохицож анхааралаа төвлөрүүлж зорисон хугацаандаа сууж сурдаг байна.

Хэрэглэх заавар:

1. Өндгөний дээд талын товчлуур эхлэх болон зогсох үйлдэл хийнэ
2. Урд талын “MODE” товчлуур дээр дарахад хийчээл хийх цаг, дахиад дарахад амрах цаг (аяганы зурагтай), дахиад дарахад энгийн дижитал цаг, дахин дарахад (alarm) буюу сэрүүлэгийн дэлгэц гарна.
3. Амрах болон сурах цагаа минут секунд дээр дарж тохируулаад дээд талын start/stop товчлуур дарахад цаг гүйж эхлэнэ. Сурах цаг гүйж дуусахад амрах цаг автоматаар гүйж эхэлнэ.
4. Та сэрүүлэг, болон энгийн цаг тохируулахдаа тухайн дэлгэц дээрээ тааруулан M товчлуур дээр 3сек-с дээш дарахад Set гарч цаг анивчина. Энэ үед M болон S товчлууруудаараа минут секундаа дээш доош нь гүйлгэж хүссэн хугацаандаа тааруулж сэрүүлэг болон цагаа тохируулах боломжтой.